



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/195-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК

Захирал: Х.Ариунзул

Утас: 99077062 Цахим хаяг: ikhayadaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Х.БЯМБАЦОО ТАНАА

2024.09.23 № СЭА-2024/195/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Түшиг сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тус сургуулийн мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа боловсролын байгууллагын онцлогт тохирохгүй байна.

018020221

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,713,321.86	202,606,744.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,624,781.21	116,021,041.54
312	Банканд байгаа бэлэн мөнгө	11,624,781.21	116,021,041.54
3121	Төгрөг	11,624,781.21	116,021,041.54
31211	Төрийн сангийн харилцах	11,624,781.21	116,021,041.54
35	БАРАА МАТЕРИАЛ	79,088,540.65	86,585,702.89
35300	Бэлэн бүтээгдэхүүн	663,000.00	782,910.00
354	Хангамжийн материал	78,425,540.65	85,802,792.89
35420	Аж ахуйн материал	35,542,940.00	40,061,755.00
35460	Хүнсний материал	900.00	1,513,800.00
35470	Бусад хангамжийн материал	42,881,700.65	44,227,237.89
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,917,534,229.25	1,916,394,097.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,917,534,229.25	1,916,394,097.69
392	Биет хөрөнгө	1,900,780,295.81	1,899,890,164.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,785,732,303.00	1,785,732,303.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(111,427,061.04)	(153,983,430.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,532,992.30	223,783,492.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(75,604,924.82)	(100,118,404.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,957,939.25	66,567,939.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,801,663.18)	(37,738,748.21)
39209	Зам, гүүрний байгууламж	18,750,000.00	18,750,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(16,150,000.24)	(16,800,000.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,149,500.00	19,149,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,304,913.28)	(4,131,141.60)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	83,356,389.00	83,356,389.00
39217	Ном	11,589,734.82	15,322,265.72
393	Биет бус хөрөнгө	16,753,933.44	16,503,933.48
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(666,666.56)	(916,666.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,170,600.00	16,170,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,008,247,551.11	2,119,000,842.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	4,862,360.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,862,360.00
413	Өглөг	-	4,862,360.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2,351,160.00
4136	Бусад өглөг	-	2,511,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,511,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,008,247,551.11	2,114,138,482.12
51	Засгийн газрын хувь оролцоо	2,008,247,551.11	2,114,138,482.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	579,511,739.58	579,511,739.58
51101	Өмч: - төрийн	579,511,739.58	579,511,739.58
512	Хуримтлагдсан үр дүн	835,724,817.39	941,615,748.40

51210	Өмнөх үеийн үр дүн	835,724,817.39	835,724,817.39
51220	Тайлант үеийн үр дүн	-	105,890,931.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	593,010,994.14	593,010,994.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,008,247,551.11	2,119,000,842.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,317,235,115.53	1,368,199,637.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,272,476,798.39	58,281,481.14
120	Нийтлэг татварын бус орлого	2,272,476,798.39	58,281,481.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,781,598.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	210,000.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	1,726,500.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	2,186,572,327.74	44,635,530.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	84,177,970.65	5,864,352.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,044,758,317.14	1,309,918,156.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	865,069,800.00	1,145,892,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,145,892,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	865,069,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	179,479,517.14	164,025,656.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	179,479,517.14	164,025,656.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,244,383,620.59	1,262,308,706.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,244,383,620.59	1,262,308,706.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,198,387,720.59	1,225,831,706.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,636,226.00	801,490,098.63
210101	Үндсэн цалин	492,982,949.12	559,318,196.32
210102	Нэмэгдэл	148,139,256.43	208,813,774.28
210104	Урамшуулал	27,514,020.45	33,358,128.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,590,544.79	98,211,082.04
210201	Тэтгэврийн даатгал	56,203,516.08	67,162,217.72
210202	Тэтгэмжийн даатгал	6,620,479.95	7,906,019.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,281,332.32	6,373,181.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,316,810.72	1,524,505.82
210205	Эрүүл мэндийн даатгал	13,168,405.72	15,245,158.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,546,225.14	148,841,256.00
210301	Гэрэл, цахилгаан	14,049,395.14	16,300,300.00
210302	Түлш, халаалт	120,861,930.00	131,791,456.00

210303	Цэвэр, бохир ус	634,900.00	749,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	284,570.00	-
210401	Бичиг хэрэг	284,570.00	-
2105	Нормативт зардал	50,537,300.00	45,072,960.00
210502	Хоол, хүнс	50,537,300.00	45,072,960.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	445,600.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	445,600.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,720,900.00	5,767,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,935,500.00	1,378,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,785,400.00	4,389,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	252,626,354.66	111,449,309.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,484,200.00	24,632,547.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,678,200.00	9,083,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	226,463,954.66	77,733,162.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,995,900.00	36,477,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,995,900.00	36,477,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,474,800.00	36,477,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,521,100.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,072,851,494.94	105,890,931.01
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	64,603,943.83	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	64,603,943.83	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(64,603,943.83)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,008,247,551.11	105,890,931.01

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,046,484,817.14	1,317,699,754.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,726,500.00	7,781,598.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,726,500.00	7,781,598.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,781,598.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	210,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,044,758,317.14	1,309,918,156.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	865,069,800.00	1,145,892,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,145,892,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	865,069,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,000.00	-

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	179,479,517.14	164,025,656.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	179,479,517.14	164,025,656.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,012,830,235.93	1,181,345,993.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,012,830,235.93	1,181,345,993.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	972,954,055.93	1,152,954,083.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,636,226.00	801,490,098.63
210101	Үндсэн цалин	492,982,949.12	559,318,196.32
210102	Нэмэгдэл	148,139,256.43	208,813,774.28
210104	Урамшуулал	27,514,020.45	33,358,128.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,590,544.79	98,211,082.04
210201	Тэтгэврийн даатгал	56,203,516.08	67,162,217.72
210202	Тэтгэмжийн даатгал	6,620,479.95	7,906,019.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,281,332.32	6,373,181.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,316,810.72	1,524,505.82
210205	Эрүүл мэндийн даатгал	13,168,405.72	15,245,158.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,546,225.14	149,025,656.00
210301	Гэрэл, цахилгаан	14,049,395.14	16,300,300.00
210302	Түлш, халаалт	120,861,930.00	131,791,456.00
210303	Цэвэр, бохир ус	634,900.00	933,900.00
2105	Нормативт зардал	51,852,160.00	52,439,700.00
210502	Хоол, хүнс	51,852,160.00	52,439,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	445,600.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	445,600.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,720,900.00	5,767,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,935,500.00	1,378,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,785,400.00	4,389,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,162,400.00	31,020,547.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,484,200.00	21,936,947.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,678,200.00	9,083,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,876,180.00	28,391,910.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,876,180.00	28,391,910.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,355,080.00	28,391,910.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,521,100.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	33,654,581.21	136,353,760.33
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,029,800.00	31,957,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,029,800.00	31,957,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,029,800.00	31,957,500.00
222001	Тоног төхөөрөмж	17,980,000.00	31,487,500.00
223001	Бусад хөрөнгө	4,049,800.00	470,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(22,029,800.00)	(31,957,500.00)

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,624,781.21	104,396,260.33
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	11,624,781.21
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	116,021,041.54

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
A	1	2	3	4
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	835,724,817.39	2,008,247,551.11
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	835,724,817.39	2,008,247,551.11
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	105,890,931.01	105,890,931.01
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	941,615,748.40	2,008,247,551.11
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	835,724,817.39	2,008,247,551.11
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	105,890,931.01	105,890,931.01
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	835,724,817.39	2,114,138,482.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,339,943,000.00	1,213,303,493.67	126,639,506.33	90.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,339,943,000.00	1,213,303,493.67	126,639,506.33	90.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,263,207,200.00	1,144,749,083.67	167,821,830.77	90.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	888,726,500.00	801,490,098.63	87,236,401.37	90.2
210101	Үндсэн цалин	620,374,000.00	559,318,196.32	61,055,803.68	90.2
210102	Нэмэгдэл	228,343,400.00	208,813,774.28	19,529,625.72	91.4
210104	Урамшуулал	40,009,100.00	33,358,128.03	6,650,971.97	83.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,090,900.00	98,211,082.04	12,879,817.96	88.4
210201	Тэтгэврийн даатгал	75,541,800.00	67,162,217.72	8,379,582.28	88.9
210202	Тэтгэмжийн даатгал	8,887,300.00	7,906,019.28	981,280.72	89.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,109,800.00	6,373,181.14	736,618.86	89.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,777,500.00	1,524,505.82	252,994.18	85.8
210205	Эрүүл мэндийн даатгал	17,774,500.00	15,245,158.08	2,529,341.92	85.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,216,500.00	149,025,656.00	9,190,844.00	94.2
210301	Гэрэл, цахилгаан	16,300,300.00	16,300,300.00	-	100.0
210302	Түлш, халаалт	140,982,300.00	131,791,456.00	9,190,844.00	93.5
210303	Цэвэр, бохир ус	933,900.00	933,900.00	-	100.0
2105	Нормативт зардал	44,234,700.00	44,234,700.00	-	100.0
210502	Хоол, хүнс	44,234,700.00	44,234,700.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,200,900.00	5,767,000.00	3,433,900.00	62.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,245,600.00	1,378,000.00	1,867,600.00	42.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,955,300.00	4,389,000.00	1,566,300.00	73.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,737,700.00	31,020,547.00	5,717,153.00	84.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,654,100.00	21,936,947.00	5,717,153.00	79.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,083,600.00	9,083,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,778,300.00	36,596,910.00	8,181,390.00	81.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,778,300.00	36,596,910.00	8,181,390.00	81.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,778,300.00	36,596,910.00	8,181,390.00	81.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,957,500.00	31,957,500.00	-	100.0

2200	Дотоод эх үүсвэрээр	31,957,500.00	31,957,500.00	-	100.0
222001	Тоног төхөөрөмж	31,487,500.00	31,487,500.00	-	100.0
223001	Бусад хөрөнгө	470,000.00	470,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,339,943,000.00	1,317,699,754.00	22,243,246.00	98.34
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,145,892,500.00	1,145,892,500.00		100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,145,892,500.00	1,145,892,500.00		100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	173,216,500.00	164,025,656.00	9,190,844.00	94.7
132001	Орон нутгийн төсвөөс	173,216,500.00	164,025,656.00	9,190,844.00	94.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,834,000.00	7,781,598.00	13,052,402.00	37.4
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,315,600.00	7,571,598.00	(4,255,998.00)	228.4
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,893,600.00	210,000.00	5,683,600.00	3.6
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	11,624,800.00		11,624,600.00	
31	Мөнгө ,түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,624,781.21		
31	Мөнгө ,түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		116,021,041.54		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
610001	Төсвийн байгууллага				
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	49	47	2	97.9
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	27	25	2	92.6
620003	Үйлчлэх ажилтан	18	18	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ерөнхий боловсролын сургууль нь "Хүүхэд бүрийн сурах тэгш боломжийг бүрдүүлж, багшийн хөгжлийг дэмжин ажиллана" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурагчдын хандлагад анхаарч, хүүхэд бүртэйгээ багш нар тулж ажиллах;
- Эрүүл, аюулгүй, амар амгалан суралцах боломжийг бүрдүүлэх;
- Багш нарыг багт нэгтгэн ажиллах;

- Мэргэжлийн хөгжлийн бүлгээрээ хамтран ажиллах, ээлжит хичээлийн цахим контентын санг нэмэгдүүлэх;
- Сурагчдын авьяас чадварыг хөгжүүлэх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд: "ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх"; "Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түшиг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,119,000.8 мянган төгрөг болж өмнөх оноос 110,753.3 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,624.8	116,021.0	104,396.2
Авлага	-	-	-
Бараа материал	79,088.5	86,585.7	7,497.2
Үндсэн хөрөнгө	1,917,534.2	1,916,394.1	(1,140.1)
Нийт хөрөнгө	2,008,247.5	2,119,000.8	110,753.3
Өр төлбөр	-	4,862.3	4,862.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,008,247.5	2,114,138.5	105,891.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,008,247.5	2,119,000.8	110,753.3

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 116,021.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны

зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.

- Бараа материалын дансны үлдэгдэл 86,585.7 мянган төгрөг болж 7,497.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 118,885.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй орлогоор 5,864.4 мянган төгрөгийн бараа материал бүртгэж, 117,253.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,916,394.1 мянган төгрөг болж 1,140.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 31,957.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 44,635.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 77,733.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.
- Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 4,862.3 мянган төгрөг нь тайлант онд үүссэн хүнсний материалын 2,351.2 мянган төгрөг, сургалт үйлчилгээний 2,511.2 мянган төгрөгийн өглөгтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 851,751.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 158,216.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг **1,009,967.6** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт **329,975.4** мянган төгрөгийн орлогыг нэмэгдүүлэн тооцож улсын төсвөөс 1,145,892.5 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 9,209.2 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 173,216.5 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 11,624.8 мянган төгрөгийг төвлөрүүлэн нийт **1,339,943.0** мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,145,892.5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 9,209.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 173,216.5 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 11,624.8 мянган төгрөг, нийт **1,339,943.0** мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,213,303.5** мянган төгрөг буюу **90.5** хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 87,236.4 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 12,879.8 мянган төгрөгөөр, байр

ашиглалтын зардлыг 9,190.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 3,433.9 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 5,717.2 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг зардлыг 8,181.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Хөтөлбөр, арга хэмжээ		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71802 – Ерөнхий боловсрол					
1	Байр ашиглалтын үйлчилгээ	2,382.1	2,382.1	-	100.0
2	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	8,050.0	7,418.8	631.2	92.2
3	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	5,359.8	639.3	4,720.5	11.9
4	Боловсролын стандарт, сургалт	781,934.2	717,591.2	64,343.0	91.8
5	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	70.0	-	70.0	-
6	Дотуур байрны үйлчилгээ	70,922.7	64,117.1	6,805.6	90.4
7	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	150.7	150.7	-	100.0
8	Сурах бичгийн түрээс	2,627.5	1,378.0	1,249.5	52.4
9	Сургалт семинар	1,191.1	1,191.1	-	100.0
10	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	214,397.6	184,494.6	29,903.0	86.1
11	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	173,216.5	164,025.7	9,190.8	94.7
12	үдийн цай хөтөлбөр	44,778.3	36,596.9	8,181.4	81.7
13	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	32,480.4	31,487.5	992.9	96.9
14	Эрүүл мэндийг дэмжих	2,382.1	1,830.6	551.5	76.8
ДҮН		1,339,943.0	1,213,303.5	126,639.5	90.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хүүхдийн хоол хүнс худалдан авах 44,234.7 мянган төгрөг төсөв батлагдсан байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг tender.gov.mn цахим сайтад байршуулж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны шалгаруулалтад "Түшиг шүтээн" ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Их наяд аудит” ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их наяд аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,244,383.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,443.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Түшиг сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд нийт 28 төрлийн 159 мэдээллийг байршуулахаас ил тод, бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 51,546.0 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснийг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,204.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс цахим төлбөрийн баримт шивэгдээгүй болон шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон асуудалд 2 албан шаардлага, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга хийх зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	2,204.6	2	2,204.6	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	3	2,204.6	3	2,204.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “ Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 905.3 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Ж.Төгсчимэгт 905.3 мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

3. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 51,546.0 мянган төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас 6,154.3 мянган төгрөгийн цахим баримтгүй худалдан авалтыг гүйцэтгэсэн.
2. Цалингийн зардал, түүнтэй холбоотой 24,900.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг журналд мөнгөн сууриар бүртгэж, тайлагнасан.
3. Журналд НДШ-ийн зардлыг 20,491.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгаж тайлагнасан
4. Авлага, өр төлбөрийг журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.

Аудитаар нийт 6,471.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,609.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,862.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Шалгуур үзүүлэлтийг харгалзалгүйгээр багш нарт тус бүр 25.0 хувиар тооцон, нийт 1,609.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг илүү бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь *"Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно" "сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%"* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйгээс хүнсний материалын 2,351.2 мянган төгрөг, Е-плас сургалт үйлчилгээний төлбөрийн 2,511.2 мянган төгрөг зэрэг нийт 4,862.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цахим баримтгүй худалдан авалт гүйцэтгэсэн	1	6,154.3			1	6,154.3	1	6,154.3				
Цалингийн зардлыг журналд мөнгөн сууриар хөтөлж, бүртгэсэн	1	24,900.3			1	24,900.3	1	24,900.3				
НДШ-ийн зардлыг журналд зөрүүтэй тайлагнасан	1	20,491.4			1	20,491.4	1	20,491.4				
Авлага, өр төлбөрийг журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.	1	-			1	-	1	-				
Дүн	4	51,546.0			4	51,546.0	4	51,546.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг илүү тооцож, олгосон	1	1,609.3	1	1,609.3								
Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн.	1	4,862.3			1	4,862.3						
Дүн	2	6,471.6	1	1,609.3	1	4,862.3						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												